

## ЗҮҮН ХОЙТ АЗИ БА МОНГОЛ УЛС

### ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХЫН ӨМНӨХ ҮЕИЙН МОНГОЛ-ЯПОНЫ ХАРИЛЦАА

Л.Бэгзжав (Ph.D)

Дэлхийн II дайны дараа олон улсын байдал үндсээрээ өөрчлөгдөж дэлхий социалист капиталист хоёр системд хуваагдсан билээ. Энэ үеэс манай улс социалист орнуудтай тал бүрийн харилцаа тогтоон хөгжүүлэхийн зэрэгцээ нийгмийн янз бүрийн байгуулалтай орнуудтай энх тайвнаар зэрэгцэн орших, хамтран ажиллах гадаад бодлого баримтлах болсон юм. Дайны дараахи жилүүдэд хүчний харилцаа социализмд ашигтайгаар үндсээрээ өөрчлөгдөхөд БНМАУ капиталист орнуудтай дипломат болон бусад харилцаа тогтоох бололцоотой болсон юм.<sup>1</sup> Ийм нөхцөлд манай улс капиталист орнуудтай харилцаа тогтоох эрмэлзлийг илэрхийлсэн зорилтыг ахин өргөнөөр тавьж эхэлсэн юм. Эдгээр зорилт нь МАХН-ын их хурлын болон бусад баримт бичгүүдэд тусгагдаж байв. МАХН-ын XIII их хурлын тайлан илтгэлд: “БНМАУ, цаашид манай улстай харилцаа тогтоохыг хүсэх бусад улсыг нийгэм, улс төрийн байгууламжийг нь харгалзахгүйгээр энх тайван зэрэгцэн орших зарчмын үүднээс тэгш эрхтэй байх, харилцан бие биеэ хүндэтгэх явдлыг үндэс болгож найрамдалт харилцаа тогтооход бэлхэн байна”<sup>2</sup> гэж тэмдэглэжээ. Мөн ийм санаа МАХН-ын дараачийн их хурлуудын материал тогтоол, шийдвэрт тодорхой тусгагдсан юм. Дайны дараахи үеийн Монгол-Японы харилцаа нэлээд өвөрмөц байлаа.

Япон Улс дэлхийн дайнд ялагдсан орны хувьд 1945-1952 онд гадаад бодлого явуулах эрхгүй, бүхий л гадаад харилцаа нь Токиод байрласан Холбоотон гүрнүүдийн Ерөнхий командлалтай харилцахаар хязгаарлагдаж байв. Энэ хугацаанд Японы цэргийн аж үйлдвэрийг устгах, эдийн засаг, санхүүгийн бүлэглэлийн тогтолцоог эвдэх алхмууд хийгдсэн юм. 1947 онд батлагдсан Японы Үндсэн хуулийн 9 дүгээр заалт ёсоор тус улс хуурай газар, тэнгис, агаарын аливаа зэвсэгт хүчингүй байх, мөн дайн хийх эрхгүй болсон байна.

1951 оны 9 дүгээр сард Холбоотон Гүрнүүд болон Хятад, Энэтхэг, Бирм зэрэг 48 орон Японтой Сан-Францискод “энхийн гэрээ” байгуулж, гарын үсэг зурснаар Японы бүрэн эрхт байдлыг сэргээв. Тухайн үед ЗХУ-ын Гадаад явдлын Яамны сайд А.Громыко уг гэрээнд гарын үсэг зураагүй

\*. ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн  
эрдэм шинжилгээний ахлах ажилтан

бөгөөд ингэснээр Зөвлөлт-Японы хооронд харилцаа сэргээх тухай асуудал хойш тавигдсан юм. Учир нь дээрх гэрээтэй нэгэн зэрэг Япон Улс, АНУ-тай аюулгүйн гэрээ байгуулж, Америкийн цэргийн баазыг нутаг дэвсгэртээ байршуулж, америкийн цэргийн хүчинд тулгуурлах болсныг Зөвлөлтийн удирдлага эсэргүүцсэнтэй холбоотой. Энэ нөхцөл байдал ч Монгол-Японы хооронд харилцаа тогтоох тухай асуудалд нөлөөллөө.

1950-иад оны II хагаст олон улсын харилцаанд түр намжмал байдал бий болсон нь Зөвлөлт Японы хоорондох харилцааг хэвийн болгох асуудлаар яриа хэлэлцээ хийх нөхцөл бүрэлдүүлсэн юм. 1956 оны 10-р сард хоёр орон хамтарсан мэдэгдэл гаргаж дипломат харилцааг сэргээхээр шийдсэн байна. 1957 онд Зөвлөлт-Японы хооронд дипломат харилцаа тогтоосны дараа манай улс Японтой зарим нэг салбарт харилцаж эхэлсэн юм. Дэлхийн II дайнаас хойш энэ үе хүртэл Монгол-Японы хооронд ямарваа харилцаа байсангүй.

1957 онд БНМАУ Японтой харилцаагаа хэвийн болгох, хоёр орны хооронд хэдийгээр хурцдаагүй ч олон жил үргэлжилсэн дайны байдлыг зогсоох талаар саналаа илэрхийлсэн юм. ЗХУ, БНМАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээний тухай Зөвлөлт, Монголын хамтарсан албан мэдээнд: “БНМАУ-ын Засгийн газар, ЗХУ, Япон улсын хооронд дипломат харилцааг сэргээн тогтоосонтой холбогдуулан баяр хүргэж, хоёр орны хоорондын харилцааг хэвийн болгох асуудлаар Японы Засгийн газартай хэлэлцээ хийхэд бэлэн байгаагаа илэрхийлж байна”<sup>3</sup> гэж тэмдэглэсэн байна.

Тэр үед Японы удирдагчид Монголын Засгийн газрын дээрх мэдэгдлийг хайхарч үзээгүй билээ. Манай улс Японтой харилцаа тогтоох асуудлыг тэвчээртэй, зорилго эрмэлзэлтэйгээр, алхам алхмаар шийдвэрлэсэн юм. Харин Японы зарим алсын хараатай улс төрийн зүтгэлтнүүд хоёр орны харилцааны хэвийн бус байдлыг өөрчлөх, БНМАУ-тай харилцааг хэвийн болгох сонирхолтой байв. 1950-иад оны II хагасаас Японы худалдааны төлөөлөгчид БНМАУ-тай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох боломжийг судлах алхам хийсэн бөгөөд манай улс ч Японтой эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх бодлого баримталж байв.

БНМАУ, Японы худалдааны төлөөлөгчид 1957 оны 10 дугаар сарын 31-нд Бээжинд хэлэлцээ хийсний үр дүнд ойрын хугацаанд худалдааны хэлхээ холбоо тогтоож, харилцан бараа нийлүүлэхээр тохиролцжээ.<sup>4</sup> Энэ бол хоёр орны хоорондын анхны албан ёсны хэлэлцээр, хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоохын үндэс суурь болсон юм.

1959 оны 7-р сарын сүүлчээр Ноён Хиро Хамазаки тэргүүтэй Японы худалдаа эдийн засгийн төлөөлөгчид Улаанбаатарт ирсэн билээ. Энэ бол БНМАУ-д Япон Улсаас ирж байгаа албан ёсны анхны төлөөлөгчид байлаа. Хоёр талын худалдааны байгууллагын төлөөлөгчид албан ёсны хэлэлцээ хийж, Монгол-Японы хооронд худалдаа хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй

байгаагаа харилцан нотолсон байна. Ингэснээр хоёр орны хооронд эдийн засаг, найрамдалт харилцааны анхны алхамыг тавьж, Монгол-Японы харилцаанд шинэ хуудас нээсэн юм.

Худалдааны харилцаа нь ард түмнүүдийн харилцан ойлголцох, харилцан ойртоход чухал шижим болдог учир Монгол-Японы худалдааны харилцааны анхны энэ алхамыг хоёр орны харилцаан дахь “шинэ үйл явдал” гэж Монголын хэвлэлд үнэлэн бичсэн юм.<sup>5</sup> Энэхүү хэлэлцээний үндсэн дээр 1960 оноос эхлэн БНМАУ-ын гадаад худалдааны нэгдэл японы худалдааны хэд хэдэн пүүс харилцан бараа солилцох болов. Манай улс японд ургамлын болон малын гаралтай түүхий эд экспортолж, японоос машин, тоног төхөөрөмж, химийн бүтээгдэхүүн, бордоо, каучук, өргөн хэрэгцээний бараа авч байв. Энэ үед манай улсын хөрөнгөтөн орнуудтай хийж байсан худалдааны ихэнх хэсэг нь Японтой хийж байсан худалдаа байв. Хоёр орны хоорондын бараа гүйлгээний нийт хэмжээ 1960 онд 40 мянган доллар, 1963 онд 70 мянган доллар, 1965 онд 455 мянган доллар байсан бол 1966 онд 570 мянган доллар, 1967 онд 922 мянган доллар болж өссөн байлаа.<sup>6</sup> 1968 оны 3-р сарын 19-нд Токио хотноо хоёр орны худалдааны 3 жилийн хугацаатай хэлэлцээр байгуулж, жил бүрийн таваарын солилцоог 1 сая долларт хүргэхээр тохирсон байна.<sup>7</sup> Японд монголын барааны талаар эрэлт хэрэгцээ өсөж, худалдааны эзэд, бизнесменүүд БНМАУ-тай худалдаа хийхийг улам бүр сонирхох болжээ. Киодо Цусин агентлагийн мэдээлснээс үзвэл, Японы 35 компани, фирм Монголтой худалдаа хийх хүсэлтэй байгаагаа мэдэгджээ.<sup>8</sup>

1970 оны 7-р сард Монголын худалдааны танхимын урилгаар “ЗХУ болон Европын социалист орнуудтай худалдаа хийх Японы ассоциацийн” ерөнхийлөгч Т.Кацураги манай оронд айлчилж хоёр талын худалдаа эдийн засгийн харилцааг цаашид хөгжүүлэх талаар хэлэлцэн тохирсон байна.

1970 оны 8 дугаар сард Монголын тал Японы Засгийн газраас олон улсын ЭКСПО-79 үзэсгэлэнг үзэж сонирхох урилгыг хүлээн авсан юм. Монголын төлөөлөгчид Японд байхдаа хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох, хоёр орны хооронд эдийн засаг, соёлын харилцааг цаашид хөгжүүлэх зэрэг асуудлаар үр бүтээлтэй санал солилцсон байна.

1950-иад оны II хагасаас Японд Монгол, Японы хооронд найрсаг харилцаа тогтоох хөдөлгөөн өрнөсөн юм. Японы хэвлэлд Монголын ард түмний ололт амжилт, амьдрал ахуйн талаар бодитой зүйл бичиж байлаа.<sup>9</sup> 1958 онд Токиод “Япон-Монголын нийгэмлэг” байгуулагдаж даргаар нь Японы парламентын гишүүн Кимико Абе, зөвлөхөөр Японы парламентын доод танхимын гишүүн Акира Казами, нийгэмлэгийн хэрэг эрхлэх даргаар Кей их сургуулийн проф.Хисаси Кава нар сонгогджээ. Гэвч тодорхой бус шалтгаанаар хожим энэ нийгэмлэг үйл ажиллагаагаа зогсоожээ. Бодит байдлыг харгалзан японы удирдагчид БНМАУ-тай харилцаа тогтоох алхам хийх болов. Эхний үед Японы засгийн газар БНМАУ-ын Варшав дахь

элчин сайдын яамаар дамжуулан Монголын төлөөлөгчидтэй албан бус хэлхээ холбоо тогтоов.

1957 онд Токиод болсон атом устөрөгчийн зэвсгийг хориглох тухай олон улсын хуралд эрдэмтэн зохиолч Ц.Дамдинсүрэн тэргүүтэй монголын энх тайвны төлөөлөгчид оролцсон юм. Японы олон нийт анх удаа Монголын албан ёсны төлөөлөгчийн дуу хоолойг тэгэхэд сонссон байна.

1957 оны эхний хэдэн сард Энх тайвныг хамгаалах Монголын хороонд японы байгууллага, олон нийтээс 40 гаруй захиа ирсэн ба зөвхөн “Хиросимагийн өнчин хүүхдүүд” хөдөлгөөнөөс 50 захидал иржээ. Эдгээр захидалд монголын олон нийтээс японы өнчин хүүхдүүдэд үзүүлсэн эд материал, мөнгө, сэтгэл санааны дэмжлэгт талархаж буйгаа илэрхийлсэн байна. Тухайлбал Ногано хотоос ирсэн нэгэн захидалд “Монгол анд найз нарынхаа халуун гарыг баяртай атгаж мэндчилье. Бид та нарын илгээсэн мөнгийг хүлээн авч их баярлалаа. Энэ бол бидний гадаад орноос авсан анхны тусламж юм” гэж бичжээ.

1956 онд Улаанбаатар хотноо Японы зураач Ири Маруки, Тошино Акамацу нарын “Атомын бөмбөгийн аюул” гэсэн зургийн үзэсгэлэн нээгдсэн нь хоёр орны соёлын харилцааны эхлэл болсон юм. 1959 онд Улаанбаатарт хуралдсан монголч эрдэмтдийн анхдугаар их хуралд Японы эрдэмтэн Абемацу, Сакамото нар оролцсон байна.

60-аад онд Монгол-Японы худалдаа эдийн засгийн харилцаа өргөжсөнийг дагалдаад Японд 1968 оны 2 дугаар сарын 20-нд Япон-Монголын найрамдлын нийгэмлэг дахин байгуулагдсан юм. Нийгэмлэг байгуулах хуралд Монголын энх тайваны байгууллагын төлөөлөгч уригдан оролцсон байна. Нийгэмлэгийн зорилго нь БНМАУ-ын бүтээн байгуулалт, ард түмний амьдралыг японы ард түмэнд танилцуулахад туслах хоёр орны хооронд дипломат харилцаа тогтооход тус дөхөм үзүүлэх, Монгол Улстай худалдааны болон бусад харилцааг идэвхжүүлэхэд хувь нэмэр оруулах явдал байв.

1963 онд Монголын жуулчны байгууллага Японтой жуулчин солилцох тухай хэлэлцээ хийсэн юм. 1966 оны 9 сарын 18-нд Монголын мэдээлэл, радиогийн улсын хороо, Японы телевизийн “NHK” нийгэмлэгтэй телевизийн киноны зураг авах тухай хэлэлцээр байгуулсан байна.

1969 онд Монголын ардын хувьсгалын 48 жилийн ойд оролцохоор манай улсад Японы парламентын төлөөлөгчид анх удаа албан бус хэмжээнд айлчилж БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга, Гадаад Явдлын Яамны сайд зэрэг албаны хүмүүстэй уулзаж хоёр орны харилцааг хэвийн болгох тухай хэлэлцээ хийв.

1971 оны 9 дүгээр сард БНМАУ-ын Засгийн газрын урилгаар Японы Либерал-ардчилсан намын парламентын бүлгийн дарга С.Накажима тэргүүтэй японы сайн санааны төлөөлөгчид Монголд айлчилжээ. Эдгээр

хэлхээ холбоо нь хоёр орны харилцааг хэвийн болгох эх суурийг тавьж байлаа.

БНМАУ-ын Засгийн газар Японтой албаны бус шугамаар хэлхээ холбоо тогтоон харилцахдаа, нийгмийн өөр өөр байгуулалтай улс орон энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг баримтлан, Азийн томоохон гүрэн болох Япон улстай албан ёсны хэмжээнд харилцааг хэвийн болгох тухай хүсэл эрмэлзэл, бүх салбарт эрх тэгш, харилцан ашигтай үндсэн дээр харилцааг хөгжүүлэхэд бэлэн байгаагаа нэг биш удаа илэрхийлж байлаа. Японы тал ч 1961, 1965, 1966, 1968 онуудад тус бүр Гадаад Явдлын Яамны 2 ажилтны бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг БНМАУ-д илгээн хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох асуудлаар санал солилцож байв.

1965 онд Японы “Токио Симбун”, “Чуничи симбун”, “Хоккайдо симбун”, “Нисинихон Симбун” сониныг төлөөлсөн сурвалжлагч ноён Итогийн тавьсан асуултад БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал өгсөн хариултандаа: Монгол-Японы найрамдалт харилцааг хөгжүүлэх талаархи манай улсын байр суурийг илэрхийлж, “Монгол, Япон хоёр хэвийн харилцаа тогтоовол манай хоёр орны ард түмний хүсэл, эрх ашигт тохирч, улс түмний энх тайван, аюулгүй байдлыг сахин бэхжүүлэх үйлсэд тус болно гэж бид үзэж байна.

Тус хоёр орны хооронд дайны байдал ёс төдий ч гэсэн байсаар байгааг эцэс болгож, япон-монголын харилцааг хэвийн байдалтай болгоход бэлэн байгаагаа манай засгийн газар бүр 1957 онд илэрхийлсэн билээ. Япон улс манай оронтой хэвийн харилцаа тогтоон сахихыг хүсвэл манай засгийн газар энэ асуудлыг авч үзэхэд бэлхэн байна” гэж тэмдэглэсэн билээ.

Мөн 1967 онд энэ асуудлаархи Монгол улсын байр суурийг дахин илэрхийлж БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал японы “Иомиури” сонины сурвалжлагч ноён Д.Оцукийн асуултад өгсөн хариултандаа: “Урьд милитарист япон улс БНМАУ-ын эсрэг зэвсэгт халдлага удаа дараа хийж, хүний амь нас, эд материалын үлэмжхэн хэмжээний гарз хохирол учруулсан нь бүхэнд илэрхий юм. Монголын ард түмэн ийнхүү хүлээсэн гарз хохирлын төлбөрийн асуудлыг Японд нэхэн тавих бүрэн эрхтэй. Гэхдээ дайны төлбөрийн асуудлыг хоёр орны харилцааг хэвийн болгох асуудалтай холболгүй жичид нь авч хэлэлцэх гэсэн санааг би хуваалцаж байна” гэж тэмдэглэсэн юм. Мөн “Монгол, Япон хоёр улсын хооронд хэвийн харилцаа тогтоох нь манай хоёр орны эрх ашигт нийцэж, Ази болон Алс Дорнодод энх тайвныг сахин бэхжүүлэхэд тус дөхөм болохсон билээ гэж японы “Майничи” сонины тавьсан асуултад хариулахдаа тэмдэглэж байлаа.

Японтой манай улс дипломат харилцаа тогтоох асуудалтай дайны төлбөрийн асуудлыг холбохгүйгээр жичид нь авч хэлэлцэх асуудал болгон тавьсан юм.

БНМАУ, Япон улсын хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоох гол саад гэж японы удирдагчдийн үзэж байсан гол асуудлын нэг болох дайны төлбөрийн асуудал ийнхүү манай улсын уян хатан байр суурь, хандлагын ачаар зөв зохистойгоор шийдвэрлэгдсэн юм.

70-аад оны эхээр олон улсын хурцадмал байдал намжиж, улс хоорондын харилцаанд нэлээд нааштай өөрчлөлт гарсан юм. Энэ үед японы Засгийн газар олон талт дипломат бодлогын концепци" дэвшүүлж, дэлхийн бүх оронтой хэвийн харилцаа хөгжүүлэх гэсэн бодлого баримтлах болов. Энэ бүхэн нь хоёр орны дипломат харилцаа тогтооход таатай гадаад орчинг бүрэлдүүлэв. Монгол-Японы Засгийн газрын хооронд явагдсан хэлэлцээрийн явцад Японы тал дайны төлбөр гэдэг нэрээр бус, хамтын ажиллагааны хэлбэрээр Монголд зохих хэмжээний хөрөнгө өгөхийг мэдэгдсэнээр харилцан ойлголцолд хүрсэн учир БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчид Японтой дайны байдлыг зогсоох тухай зарлигийг 1972 оны 2 дугаар сарын 11-нд гаргасан байна. Ийнхүү Монгол Японы Засгийн газар олон удаа хэлэлцэн тохирсны үр дүнд 1972 оны 2 дугаар сарын 24-нд БНМАУ, Японы улсын хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоосон юм. Энэ нь хоёр орны харилцааны бүхий л үеийн туршид тэмдэглэгдэх түүхэн үйл явдал болсон бөгөөд хоёр орны харилцааны цаашдын олон талын хэлхээ холбоог өргөжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой үйл явдал байлаа. Ингэж хоёр орны харилцааны шинэ үе эхэллээ.

## ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Б.Лигдэн. БНМАУ-ын гадаад харилцааг хөгжүүлэх талаар МАХН-аас явуулсан үйл ажиллагаа (1945-1970, УБ., 1976. 121-р тал)
2. МАХН-ын XIII их хурлын материал. УБ.1958.20-р отал.
3. "Правда" 1957.5.17.
4. "Үнэн" 1957.11.4.
5. "Үнэн". 1959.8.1. № 180.
6. "Үнэн" 1968.8.30. №243.
7. "Новости Монголии" 1968.3.23. №24.
8. 1957 онд Японы "Секай Шочо" сэтгүүлд Японы зохиолч Мурамацугийн "Гадаад монгол шинэ замаар урагшилж байна" гэсэн өгүүлэл гарсан юм. Мөн Хиросимад хэвлэгддэг "Аюэми" сонины 1957 оны № 7-ийн "Хиросимагийн өнчин хүүхдүүд" гэсэн тэргүүн өгүүлэлд монголын энх тайвын хорооноос япончуудад тусалсан тухай "Асахи" сонины сурвалжлагч Тайко Мацуко "Социализмд хүрэх жигүүр" гэсэн өгүүлэл нийтлүүлжээ.
10. Энхтайваны найрамдлын байгууллагуудын гүйцэтгэх хорооны архив
11. Вага чайко-но кинкё. Токио. 1970. №14. 90-р тал.
12. "Үнэн" 1965.12.22. № 356.
13. "Үнэн" 1967.4.29.
14. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. III боть. УБ.1972. 434-435-р тал.
15. С.Дамбадаржаа. Өгөөжтэй хорин жил. "Дорно-Өрнө" сэтгүүл. 1992. № 1.
16. Л.Хайсандай. Монгол-Японы өнөөгийн харилцаа: эерэг хандлага, өөдрөг үйл явц. "Зүүн хойт Ази судлал" сэтгүүл. 1996. № 1/7/
17. С.Дамбадаржаа. Дурьдсан өгүүлэл.
18. Мөн тэнд.
19. Монгол-Японы харилцаа. Эрт, эдүгээ. УБ. 1998.35-р тал.
20. Ч.Улаан. Монгол-Японы хамтын ажиллагаа: эрт, өдгөө, ирээдүй. "Засгийн газрын мэдээ" 1995.7.19. № 83.